

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.3, 46.4, 46.7, 46.8, 46.10, 46.14, 46.15 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.16 дахь заалт болон 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны 2023 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж энгийн хувьцаанд 1,033.00 (Нэг мянга гучин гурван) төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.

2. Ногдол ашиг хуваарилах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах өдрийг Банкны 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

3. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд олгох ажиллагааг банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хангалттай уялдуулан эрх бүхий зохицуулагч байгууллагаас зөвшөөрлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан хэрэгжүүлэх, хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д үүрэг болгосугай.

4. Ногдол ашиг хуваарилсантай холбоотой тайлан, мэдээг холбогдох журмын дагуу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлэх болон дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА